САНГИЙН ЯАМ

# ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-д тусгагдсан арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулж байна.

Дээрх төлөвлөгөөнд Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх нийт 52 арга хэмжээ байгаа бөгөөд үүний 8 арга хэмжээг үндсэн хариуцагчаар, 44 арга хэмжээг хамтран хариуцагчаар хийж гүйцэтгэхээр тусгагдсан байна.

Үндсэн хариуцагчаар хийхээр тусгагдсан 8 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 7, үнэлэх боломжгүй 1 арга хэмжээ байна. Хамтран хариуцагчаар хийхээр тусгагдсан 44 арга хэмжээнээс 100 хувийн хэрэгжилттэй 17, 30 хувийн хэрэгжилттэй 3, үнэлэх боломжгүй 14 , Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй 10 арга хэмжээ байна, ерөнхий дүнгээр 89.5 хувийн үнэлгээтэй байна.

Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 10 арга хэмжээ байгаа нь Эдийн засаг, хөгжлийн яам толгойлон хэрэгжүүлэх ажлууд байх тул хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулаагүй бөгөөд хэрэгжилтийг дээрх байгууллагаас гаргуулан авах нь зүйтэй байна.

**“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ**

(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

| № | Бодлого | Арга хэмжээ | Хэрэгжилт | | | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 30 | Хамааралгүй | Үнэлэх боломжгүй | |
| 1 | Хүний хөгжлийн бодлого | 17 | 6 | | 2 | 9 | 100 |
| 2 | Эдийн засгийн бодлого | 28 | 14 | 3 | 7 | 4 | 87.7 |
| 3 | Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого | 4 | 3 | | | 1 | 100 |
| 5 | Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого | 3 | 1 | | 1 | 1 | 100 |
| **Нийт** | | **52** | **24** | 3 | **10** | **15** | **96.9** |

**2023 оны эхний хагас жил**

| Д/д | Зорилго | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Хүний хөгжлийн бодлого | | | | | | | |
| 1 | 1.2. Судалгаа хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ. | 1.2.1.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх (Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар) | Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар | 0.18 | . | 2023 онд шинжлэх ухааны салбарын санхүүжилт нь 47.7 тэрбум төгрөг батлагдсаны 75.1 хувь буюу 38.1 тэрбум төгрөг нь урсгал зардал, 24.9 хувь буюу 12.6 тэрбум төгрөг эрдэм шинжилгээний ажлын зардал бөгөөд 2023 оны төсвийн тодотголоор эрдэм шинжилгээний ажлын зардал 9.6 тэрбум төгрөг байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.1 хувийг эзэлж байна. | 100% |
| 2 | 1.3. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, | 1.3.2.1. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Сүрьеэгийн эмнэлгийн | Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар | 20 | . | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд 18,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 2,000.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй батлагдсан бөгөөд уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарласан бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар санхүүжилт аваагүй | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | барилгын ажлын явц, хувиар) | | | | байна. Тиймээс үнэлэх боломжгүй. | |
| 3 | | 1.3.2.2. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Зүрх судасны төвийн барилгын ажлын явц, хувиар) | Зүрх судасны төвийн барилгын ажлын явц, хувиар | 10 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно. | Хамааралгүй |
| 4 | | 1.3.2.3. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлын явц, хувиар) | Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлын явц, хувиар | 10 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно. | Хамааралгүй |
| 5 | | 1.3.2.4. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, | Геронтологийн төвийн барилгын | 80 | . | Тухайн төсөл, арга хэмжээ нь анх 2011 оноос төсвийн тухай хуулиар батлагдан хэрэгжиж байгаа бөгөөд барилгын хийц | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Геронтологийн төвийн барилгын ажлын явц, хувиар) | ажлын явц, хувиар | | | бүтээц дээр мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, төсөвт өртгийг нягтлах шаардлагатай тул санхүүжилтийг зогсоосон. Түүнчлэн тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд санхүүжилт батлагдаагүй байна.Тиймээс үнэлэх боломжгүй. | |
| 6 | | 1.3.2.5. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ын барилгын ажлын явц, хувиар) | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ын барилгын ажлын явц, хувиар | 10 | . | Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Барилга, хот байгуулалтын сайдын багцад хэрэгжсэн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд зураг төсөл нь бүрэн хийгдэж Барилгын хөгжлийн төвөөр магадлалын ерөнхий дүгнэлт баталгаажсан. Түүнчлэн тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бөгөөд Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд санхүүжилт батлагдаагүй байна. Тиймээс үнэлэх боломжгүй. | |
| 7 | | 1.3.2.6. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ын барилгын ажлын явц, хувиар) | Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ын барилгын ажлын явц, хувиар | 10 | . | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Барилга, хот байгуулалтын сайдын багцад хэрэгжсэн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд зураг төсөл нь хийгдэж байгаа бөгөөд зураг төслийн гэрээ 70 хувьтай хэрэгжиж байна. Түүнчлэн тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд санхүүжилт батлагдаагүй байна. Тиймээс үнэлэх боломжгүй. | Үнэлэх боломжгүй |
| 8 | | 1.3.2.7. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний | Баянзүрх дүүрэг дэх 300 ортой эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар | 20 | . | Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилгын зураг төсөлд холболт хийж гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүртээмжийг сайжруулах (Баянзүрх дүүрэг дэх 300 ортой эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар) | | | | /Улаанбаатар, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг/ төслийн явц газрын асуудал шийдэгдэж зургийн ажил боловсруулах шатанд байна. Түүнчлэн тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд санхүүжилт батлагдаагүй байна. Тиймээс үнэлэх боломжгүй. | |
| 9 | | 1.3.2.9. Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилгын ажлын явц, хувиар) | Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилгын ажлын явц, хувиар | 100 | . | Монгол Улсын 2022 оны төсвийн хуулийн 2 дугаар хавсралтад Эрүүл мэндийн сайдын багцад тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилт батлагдсан болович гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулаагүй тул 2023 оны төсвийн тухай хуульд санхүүжилт батлагдаагүй байна. Тиймээс үнэлэх боломжгүй. | Үнэлэх боломжгүй |
| 10 | | 1.3.3.2. Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх (Телемедицин нэвтрэх | Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллагын тоо | 35 | . | Алсын зайн анагаах ухааны системийг Улсын гуравдугаар төв эмнэлгийн зүрхний төвийн санаачлагаар МН кардио програм хангамжийг ЭМЯ-ны Техникийн хороо болон Мэдээллийн технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж ашиглах шийдвэр 2022 оны 04 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрүүл мэндийн байгууллагын тоо) | | | | сарын 15нд гарсан. Тус програм хангамжийг хувийн 4 эрүүл мэндийн байгууллага, Анхан шатлалын 212 эрүүл мэндийн байгууллага, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв болон 9 дүргийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн яамны харьяа 4 байгууллага холбогдон зүрх судасны чиглэлээр эмнэлзүйн хэлэлцүүлэг, хариу зөвлөгөө зэрэг үйл ажиллагаанд ашиглаж байна. | |
| 11 | 1.4. Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 1.4.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих "Найрамдал-2" зуслангийн цогцолбор барих | Барилгын ажлын явц, хувиар | 40 | . | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, ХНХ-ын сайдын багцад “Олон улсын Хүүхдийн Найрамдал-2 зуслан” цогцолбор төсөл /Хөвсгөл, Хатгал сум/ төсөл арга хэмжээг 2022-2025 онд 30.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг, 1.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэйгээр батлагдсан, 2022 онд нэг удаа, 2023 онд 1 удаа гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарласан боловч амжилтгүй болсон байна.Тиймээс үнэлэх боломжгүй. | Үнэлэх боломжгүй |
| 12 | 1.5. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч | 1.5.2.1. Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, | Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур | 100 | . | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ. | хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар) | чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | | | 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх 4 үндсэн үйл ажиллагаа/хөтөлбөр/-г хэрэгжүүлэхээр баталсан. Эдгээр үйл ажиллагаанаас иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлтэй Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа тус тус байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын үйл ажиллагаанд 2023 оны 05 сарын байдлаар өссөн дүнгээр 2672 иргэн хамрагдаж, 138,283,000 төгрөгийг зарцуулсан байна. Үйл ажиллагаа тус бүрээр нь авч үзвэл: - Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 2346 иргэн хамрагдаж, 130,589,000 төгрөгийг; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны сургалтын арга хэмжээнд 326 иргэн хамрагдаж, 7,694,000 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээ тус бүрээр нь авч үзвэл: -Сууръ ур чадварын сургалтад 868 иргэн хамрагдаж, 25,110,000 төгрөгийг; - Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 384 иргэн хамрагдаж, 71,257,000 төгрөгийг; -Аж ахуй эрхлэлтийн сургалтад 1025 иргэн хамрагдаж, 18,920,000 төгрөгийг; -Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад 50 иргэн хамрагдаж, 9,240,000 төгрөгийг тус тус зарцуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны сургалтын үйл ажиллагааг арга хэмжээ тус бүрээр авч үзвэл: -Аж ахуй эрхлэлтийн сургалтад 316 иргэн хамрагдаж, 6,002,000 төгрөгийг; -Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 10 иргэн хамрагдаж, 1,632,600 төгрөгийг тус тус зарцуулсан. | |
| 13 | | 1.5.2.4. Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх | 50 | . | Монгол Улсын 2023 төсвийн тухай хуульд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ төсөл арга хэмжээг | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар) | Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар | | | 2022-2024 онд 13,277.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4,164.3 төгрөгийн санхүүжих дүнтэйгээр хэрэгжүүлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар санхүүжилт гараагүй бөгөөд барилгын ажил 15 хувьтай хэрэгжиж байна. Тиймээс тус арга хэмжээг үнэлэх боломжгүй байна. | |
| 14 | | 1.5.3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдэд ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Дэмжлэгт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдийн тоо | 400 | . | Орон нутгийн ипотекийн 3 хувийн хөнгөлөлттэй зээлийн Санхүүжилтийн ерөнхий гэрээг эцэслэн баталгаажуулсан бөгөөд хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкнуудаар олгож эхлээд байна. Улаанбаатар хотоос үйл ажиллагаагаа орон нутагт шилжүүлсэн аж ахуй нэгжид олгох 1 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний төсөлд Монголбанкнаас санал авахаар албан бичиг явуулсан бөгөөд саналыг ирэхээр санхүүжилтийн гэрээнд тусган талуудаар баталгаажуулахаар ажиллаж байна. Мөн 2023 оны төсөвт ажлын байрыг дэмжих чиглэлээр 72.2 тэрбум төгрөг, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орон нутаг суурших иргэдэд 15.7 тэрбум төгрөг, төвлөрлийг сааруулах чиглэлээр 12,7 тэрбум төгрөгийг хүүгийн татаасыг Сангийн сайдын багцаас шийдвэрлэхээр, мөн Хүнс, хөдөө аж аухйн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжид 213.3 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг олгохоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдэврийн багцаас шийдвэрлэхээр төсөвт тусгасан. | |
| 15 | | 1.5.5. Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 100 | . | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “тэтгэврийн зөрүүг ойртуулах” зорилтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэврийн хэмжээг 2 үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөн Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголыг Улсын Их Хуралд өргөн барьсан. 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт өндөр настны тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг тогтооход баримталсан цалин хөлсийг 2022 оны дундаж цалингаар суурь болгон шинэчлэн тооцно. Энэ арга хэмжээний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үр дүнд ижил цалин хөлсөөр ойролцоо хугацаанд ажиллан шимтгэл төлсөн боловч тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хамаарч хоорондоо зөрүүтэй тэтгэвэр авч байгаа 164.6 мянган өндөр настны тэтгэврийн зөрүүг арилгана. Үүний зэрэгцээ тэтгэврийн зөрүүг арилгасны дараах сууриас тооцож тэтгэврийн хэмжээг үнийн өсөлттэй уялдуулж 10.0 хувь нэмэхээр тооцсон ба 496.3 мянган хүний тэтгэвэр нэмэгдэхээр байна. | |
| 16 | 1.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1.6.1.2. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих (Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын явц, хувиар) | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын явц, хувиар | 100 | . | Монгол Улсын 2023 төсвийн тухай хуульд Барилга, Хот байгуулалтын сайдын багцад хэрэгжсэн "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд зураг төсөл нь бүрэн хийгдэж Барилгын хөгжлийн төвөөр магадлалын ерөнхий дүгнэлт баталгаажих шатандаа хэрэгжиж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын санхүүжилтийн эх үүсвэр Монгол Улсын 2023 оны | Үнэлэх боломжгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсвийн тухай хуульд шийдвэрлэгдээгүй байна. Тиймээс үнэлэх боломжгүй байна. | |
| 17 | | 1.6.2.4. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих (Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо) | Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо | 15 | 2 барилга байгууламж, 1,045.6 сая төгрөг | Монгол Улсын 2023 төсвийн тухай хуульд Соёлын сайдын багцад Орон нутгийн судлах музейн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/ төсөл, арга хэмжээнд 889.3 сая төгрөг, мөн Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Булган сум/ төсөл арга, хэмжээнд 265.5 сая төгрөгийн тус тус санхүүжилт батлагдаж ашиглалтад орсон. | 100% |
| 2. Эдийн засгийн бодлого | | | | | | | |
| 18 | 2.1. Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, өрийн менежментийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангана. | 2.1.1. Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах мөнгөний бодлого хэрэгжүүлэх | Инфляцын түвшин, хувиар | 6±2 | . | "Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомслоос сэргийлэх , сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийг УИХ-аар 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр батлуулсан. Тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т "Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах" гэж заасны дагуу 8 компанид 120 мян.тонн АИ-92 автобенкинийг тонн бүрийг 840 доллароор авч литр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тутмын үнийг 2,390 төгрөгөөс хэтрүүлэхгүй байх заалтыг тусгасан. Тус хуулийн дагуу "Роснефть" НХН-тэй автобензин тоон бүрийг 25 хувь хямдаар авах хэлцэл хийсэн ба тус гэрээний дагуу сүүлийн 15 сарын хугацаанд АИ-92 автобензиний үнэ 2390 дээр тогтвортой хэвээр байна. Энэхүү арга хэмжээ нь 2022 оны 6 дугаар сард 16.9 хувьд хүрээд байсан инфляцыг 2023 оны 5 дугаар сарын байдлаар 11.3 хувь болж буурахад чухал нөлөө үзүүлсэн. | |
| 19 | | 2.1.2.1. Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх (Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь) | Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 65 хувиас хэтрэхгүй | . | Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 49.7 хувьтай тэнцэж байгаа бөгөөд хагас жилээр хүлээгдэж буй гүйцэтгэл 46.3 хувьтай тэнцэхээр байна.<br><br>Хавсралт : 2 файл | 100% |
| 20 | | 2.1.2.2. Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан | Засгийн газрын гадаад өрийн дотоодын нийт | 60 хувиас хэтрэхгүй | . | Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 53.5 хувьтай тэнцэж байгаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх (Засгийн газрын гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь) | бүтээгдэхүүнд эзлэх хувь | | | бөгөөд хагас жилээр хүлээгдэж буй гүйцэтгэл 50.3 хувьтай тэнцэхээр байна. Энэ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан шалгуурт бүрэн нийцэж байна.<br><br>Хавсралт : 2 файл | |
| 21 | | 2.1.2.3. Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх (Төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь) | Төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 3.6 | . | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн өрийн нийт хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаар болох ДНБ-ий 65 хувь буюу 35.4 их наяд төгрөгөөс давахгүй байхад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд төсвийн алдагдлыг 1.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 2.6 хувьтай байхаар тооцсон. | 100% |
| 22 | 2.2. Боомтын сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж, экспортыг нэмэгдүүлнэ. | 2.2.1.1. Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих (Хилийн боомтуудыг орчин үеийн технологи бүхий хяналт шалгалтын тоног | Хилийн боомтуудыг орчин үеийн технологи бүхий хяналт шалгалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар | 100 | 1.Сүхбаатар – 329,9 сая төгрөг, АХБ, 3.365,5 сая 2. Улсын төсөв - 502.8 сая төгрөг, 3. Замын-Үүд боомт буцалтгүй тусламж - 85,146.4 сая | 1 .Алтанбулаг – 10 Замын-Үүд – 10 Сүхбаатар – 10 Боршоо - 10 2.Алтанбулаг авто зам-70, барилга байгууламж-75, Сүхбаатар – 100 Боршоо авто зам-70, барилга байгууламж-75, Бичигт авто зам - 20, барилга байгууламж-13 ( Тайлбар: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар багийн нутагт дэвсгэрт 600м2 талбайтай газар дээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар) | | | төгрөг, Улсын төсөв -16,109.0 сая төгрөг | байрлах, нийт 2,850 м2 талбай бүхий 6 давхар, зоорийн давхартай, контор, олон нийтийн үйлчилгээний зориулалт бүхий “Нэг цэгийн үйлчилгээний цогцолбор”-ын барилга угсралтын ажлыг дуусгаж, 2022 оны 12 сарын 21-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн. Ингэснээр зорчигчид болон гадаад худалдаа эрхлэгчдийн төмөр замын боомт дээр зарцуулж буй цаг хугацаа, зардлыг бууруулах, улмаар боомтоор түргэн шуурхай нэвтрэх боломж бүрдэж эхлэх нөхцөл бүрдлээ. Боршоо хилийн боомтын доторх 31,400 м2 зам талбай, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг дуусгаж, 2022 оны 11 сарын 7-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн. Түүнчлэн Боршоо хилийн боомтын барилга байгууламжийн угсралтын ажлыг дуусгаж, 2023 оны 2-р улиралд багтаж улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангаж байна. Хилийн боомтыг шинэчлэн зохион байгуулан өргөтгөх замаар зорчигч, тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлэхэд зарцуулах цаг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацааг багасгаснаар худалдаа хөнгөвчлөгдөж, гадаад худалдааны эргэлт нэмэгдэнэ. Хяналт шалгалтын тоног төхөөрмж нийлүүлэх тендерийн бичиг баримтын төслийг боловсруулан, Үнэлгээний Хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулан, АХБ-аас зөвшөөрөл авч, зарыг 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулсан. Нийт 30 гаруй үйлчилгээг иргэн, ААН цахимаар авах боломжтой болсон. Тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг 2 үе шаттайгаар хийж, захиалагчид хүлээлгэн өгсөн.) 3. “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх” төслийн Бүрэлдэхүүн 1 буюу "Замын-Үүд" чөлөөт бүсийн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах ажлын хүрээнд Нарийвчилсан инежэнерийн зураг төсөл боловсруулах зөвлөх компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>Хавсралт : 3 файл | |
| 23 | | 2.2.1.2. Боомтуудын зорчигч болон ачаа | Шивээхүрэн боомтын | 100 | 1.Сүхбаатар – 329,9 сая | Шивээхүрэн боомтын өргөтгөл, шинэчлэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих (Шивээхүрэн боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажлын явц, хувиар) | өргөтгөл, шинэчлэлийн ажлын явц, хувиар | | төгрөг, АХБ, 3.365,5 сая 2. Улсын төсөв - 502.8 сая төгрөг, 3. Замын-Үүд боомт буцалтгүй тусламж - 85,146.4 сая төгрөг, Улсын төсөв -16,109.0 сая төгрөг | ажлын явц, хувиар; ХБҮЗ-ийн 2021 оны 02 дугаар тогтоолоор Шивээхүрэн боомтыг өргөтгөж шинэчлэх шинэ төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах төлөвлөгөө батлагдсан. Шивээхүрэн боомтын ТЭЗҮ, БОТБҮ, төлөвлөлтийн эскиз зураг, инженер геологийн хайгуул судалгаа, геодезийн хайгуулын судалгаа, байр зүйн зураг, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг "Татах хүч" ХХК гүйцэтгэж байна. Зураг төслийн ажлын гүйцэтгэл 100%, ТЭЗҮ барилгын хөгжлийн төвийн экспертизээр батлагдсан. Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дэд бүтэц, барилгын ажлын явц, хувиар; Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Л3936-МОН: "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн CS01: Замын-Үүд чөлөөт бүсийн барилгын ажлын нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулж байгаа ""Сонголт дизайн"" ХХК нь гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний цогцолборын барилгын загвар зураг төслийг боловсруулан санал авахаар хүсэлт ирүүлсний дагуу холбогдох нэгжүүдээс дотоод зурвасаар саналыг авч, нэгтгэн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр 02-1/2045 дугаартай албан бичгээр төсөлд тусгах саналыг хүргүүлсэн Барилга байгууламжийн угсралтын ажил 2024 оны 2-р улиралд эхэлнэ./<br><br>Хавсралт : 3 файл | |
| 24 | | 2.2.2.1. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар) | Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар | 50 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно | Хамааралгүй |
| 25 | | 2.2.2.2. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг | Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто | 30 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр | Хамааралгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх (Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар) | замын барилгын ажлын явц, хувиар | | | тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно | |
| 26 | | 2.2.2.3. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар) | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар | 100 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно | Хамааралгүй |
| 27 | | 2.2.2.4. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт | Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замын барилгын | 100 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу | Хамааралгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чиглэлийн 120.85 км авто замын барилгын ажлын явц, хувиар) | ажлын явц, хувиар | | | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно. | |
| 28 | | 2.2.2.5. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар) | Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | 30 | . | Монгол Улсын 2023 төсвийн тухай хуульд Зам тээврийн хөгжлийн сайдын багцад Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/ төсөл, арга хэмжээнд 19,461.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэл ирүүлээгүй тул санхүүжилт олгогдоогүй байна. Тиймээс үнэлэх боломжгүй болно. | Үнэлэх боломжгүй |
| 29 | | 2.2.2.6. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар) | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар | 100 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ | Хамааралгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно. | |
| 30 | | 2.2.2.7. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар) | Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 100 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно. | Хамааралгүй |
| 31 | | 2.2.2.9. Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх (Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар) | Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 100 | . | Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэхээр тусагдсан байх бөгөөд тус асуудал нь 2022 оны 12 сары 09-ний өдөр батлагдсан "Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль"-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар байна. Тиймээс уг арга хэмжээ Сангийн яамны чиг үүрэгт хамааралгүй болно. | Хамааралгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
